

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXX (463)

2016

(56-60)

“ЗАРАХ”-ЫН УТГА ХЭРЭГЛЭЭНД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Болор *

Агуулгын товч: Тус өгүүлэлд “зарах” гэдэг үгийн утгийг дурсгалт бичгүүд дэх тэмдэглэлээс мөрдөж, одоо үеийн монгол хэлэн дэх салбар утгыг тунгаан, Өвөр монгол болон халх монгол аялгуун дахь “зарах”-ын хэрэглээний ялгааг тодруулахын улмаас монгол хэлний үгийн сангийн дан үгийн утгын хувьсалын онцлогыг товойлгохоор зорив.

Бодис барааг хураан хадгалдаг сан хөмрөг шиг хэлэнд бас үгийн сан гэж байна.¹ Хэрвээ нэг хэлийг барилгын ажлаар жишээлэхэд хүрвэл үгийн сан нь хэлний барилгад дутагдаж болшгүй нэг хэсэг болж хэлний баялгийн үнэн мөн тусгал болдог. Ингэхэд дэлхийн хэлнүүдээс дутуугүй байдаг монгол хэлний минь үгийн сан ч маш баялаг байж, нэг үгээр олон утга илтгэх ба олон үгээр нэг утга илтгэх тохиолдол зөндөө олон байдаг. Гардиас “Орчин цагийн монгол хэл” номдоо “Монгол хэлний үгийн сан нь хөгжил улирлаар урт удаан болох түүхэн уламжлалтай. Дурсгалт бичгүүдээс үзвэл мянгаад жилийн турш нэлээд олон үг нь хэвээр уламжлагдсан буюу хөгжил улбаатайгаар хэрэглэгдсээр билээ. Үүнд маш олон үндсэн үг, мал аж ахуй ба ан гөрөөнд холбогдох үг бол даруй ийм байж эдгээр үгс нь монгол хэлний үгийн санд харьцангуй тогтвортой, тухайн хэрэгцээндээ элбэг хүрэлцэхүйц болж байсаар байгааг харуулж байна”, “Үгийн утга нийгэмч чанартай. Энэ нь хүмүүсийн нийтийн зуршил хэрэглээнээс болсон юм. Үүнийг үгийн утгын тогтворт чанар ба дуршилт чанар хоёр талаас ойлгож болох юм” гэжээ. “Зарах” гэдэг үгийн утгын хувьсал нь яг дээрх жам ёсоор хөгжсөн байна.

Монголын эртний дурсгалт бичгүүдийн агуулгаас сүвэгчилбэл, “зарах” гэдэг үгийн хамаг анхны тэмдэглэл нь “Монголын нууц товчоо”-нд байж, “Добун мэргэн тэр үг дүр цөө бугын өрөөл гуя ину хугалж өгч тэр хөвгүүнийг авчирч гэр дотор зарж аху бүлгээ”² өгүүлбэрт “тэр хөвгүүнийг гэр хооронд зарцалж, ажил хийлгэ” гэх утгаар хэрэглэжээ. Үүний дараа 1299 онд зохиож дуусгаад 1312 онд дармалагдсан “Бодьчарияа авадрагийн тайлбар”-ын үлдэгдэлд “сэтгэлээ зарваас болох болж бясалгах болтугай шимнанц нар олзат болоод”³ гэж байна. Эндэх “сэтгэлээ зарваас” гэдэг нь “оюун тархиа хэрэглэж”

* БНХАУ, Өвөр Монголын их сургууль

¹ Гарьд (2007), Орчин цагийн монгол хэл. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

² Баярын буулгасан (1980), Монголын нууц товчоо. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

³ Дов эмхэтгэсэн (1983), Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд, Үндэстний хэвлэлийн хороо.

гэсэн утгатай болжээ. Тэгвэл 1335 онд босгосон “Жан Ен Шуйгийн ордост босгосон хөшөөний бичиг”-ийн арван хоёрдугаар зурвас дахь “тэр ба эд таваар зөөж өгвөөс зарж барах цаг болж, сайн авир ургийн ураг хүртэл баршгүй тус болму за хэмээн өгүүлбээс ...”⁴ өгүүлбэрийн “зарж” гэдэг нь “эдэлж” гэсэн утгатай байна. 1338 онд босгосон “даргач Жигүндэйн хөшөөний бичиг”-т “жич мөн одон барваас бидний орд дотор ямар ба үйл болвоос, зарагдах хэрэгт хүнгүй болжуу хэмээн өчиж бүрүн ... газарт даргач болгоод ...”, “дайнаар бөгөөс Дивабалун эрдэм ухаан ину дуустал зарагдах үйлгүй хэмээн хайрлан”⁵ гэх хоёр тэмдэглэлийн өмнөх “зарагдах” нь “ажилд томилох, хүнд ажил тушаах” утгаар хэрэглэгдэж, хойнох “зарагдах” нь “тархиа хэрэглэх, оюун санаагаа зарцуулах” гэсэн утгаар оржээ. 1453 онд бичигдсэн “Енлиркид буулгасан зарлиг”-т “тэнгэрийн уурыг хүндлэн даган, дээдсийг эрхлэн, хүн зарж холоос уулжирангаа үзүүлэн ирснээс чин үнэн зориг үзэгдвэй”⁶ -н “зарах” гэдэг нь “хүн томилох, элч томилох” утгаар хэрэглэгджээ. Үүний дараагаар 1581 онд бичигдсэн “Алтан хааны бодрол бичиг”-т “хууль ёсонд оруулж үзүүлэн, түшмэл Сун төвд харь ирсэн зарж гадаад элчин төрнө өрнө үтэрлээ”-д “элч явуулах” утгатай байна. “Мин улсын үеийн зарлиг ба айлтгал бичгүүд”-д “эдүгээ зорин зарж элчин аван зарлиг бүү тунгааж чин зориг ...”, “чи мэргэн хүндлэн даган тэнгэрийн уурыг эрхлэн дээдсийн зарж элчинийг архүү морин ир оруулж чин үнэн зориг хө хийе”, “би нар сонс улсаа бишрүүл, зарж хүн дээдсийн урьд өчмү гэлээ”⁷ гурван өгүүлбэр дэх “зарж” нь бүр “элчин явуулах” утгаар хэрэглэгдэж “түмэн настай сайн үтэр, уулжиранаа үзүүлсэн агт хоёр ба тэмээн нэгэн чи, зарж чихуй нохой төмөр мөргөчихөв” өгүүлбэрт “эдэлж хэрэглэх” гэх утгатай буй.

Нэг хэлний хэлц үг нь тухайн хэлнийхээ дархлаа болдог гэж судлаачид үздэг. Тиймээс монгол хэлний “зарах” агуулж байгаа зүйр цэцэн үгийг би лавтай “зарах” гэдэг үгийн үндэс буюу гол утгын тодорхойлолд үндэс болж чадна гэж үзнэ. Тийнхүү энд би “зарах” агуулж байгаа цэцэн үгээс хэдийг сийрүүллээ. Бидний мэдээжээр мэргэдийн үгэнд “зарах дүүтэй, захирах ахтай”, “зарахдаа хүргэн зөөлөн, залахдаа яргуй зөөлөн” гэж гардаг. Тэгвэл энэ хоёр үгэн дэх “бусдаар ажил хийлгэх” гэсэн санаа болох нь гарцаагүй. Үүнээс гадна “зарахын үедээ замдаа буй, зарсан хойноо яамандаа буй”, “зарсанаа мэдэж хэрэглэхээ жиш, хурааснаа үзэж хүрэлцэхээ зөвлө” гэх хууч үгүүдэд “эдэлж хэрэглэх” утгаар хэрэглэгдсэн байдал бас байна.

Иймээс дээрх олон жишээнүүдийг хураангуйлбал, Дундад эртний монгол хэлэнд “зарах” гэдэг үйл үг нь “бусдаар ажил хийлгэх, элч явуулах, оюун ухаанаа зарцуулах, эдэлж хэрэглэх” зэрэг утгатай байжээ. Мөн ч дурсгал бичгүүдийн бичигдсэн он тооллын дэс дараа жич “зарах” гэдэг үгийн өгүүлбэрт орсон утгаас баримтлаад энэ үгийн утга нь харьцангуй тогтвортой байсныг мэдэж болно. Нэн хэлц үгийн утга хэрэглээг үндэслэн “зарах”-ын үндсэн утгыг “бусдаар ажил хийлгэх”-д буй гэж үзэж байна. Гэвч энэхүү тогтворт байдал нь орчин одоо үе болоход эвдэгдэж, үгийн утга нь хувьсаад үндсэн “зарцлах” жич уул салбар утгаасаа гадна нэн олон утгаар салбарлах болсон байна.

Бодтойгоор хэлбэл:

⁴ Дов эмхэтгэсэн (1983), Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд, Үндэстний хэвлэлийн хороо.

⁵ Дов эмхэтгэсэн (1983), Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд, Үндэстний хэвлэлийн хороо.

⁶ Дов эмхэтгэсэн (1983), Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд, Үндэстний хэвлэлийн хороо.

⁷ Дов эмхэтгэсэн (1983), Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд, Үндэстний хэвлэлийн хороо.

1. Шагж багшийн “Монгол хэлний тайлбар толь”-д “зармуй” гэдэг үгийг “хүнийг бус газраа илгээхүйг бас хүнийг үйлдүүлэхийг, бас морь малыг эдлэхүйг ч, бас эдүгээ мөнгийг худалдахуйг ч” хэмээн тайлбарлаж, “зарцалмуй”-г “хүнийг ойр ахуулж бага сага зарахуй”-г гэж тайлбарлажээ.

2. “Монгол хэлний тайлбар толь” дахь “зарах”-ын утга:

1/ Ямар нэгэн үйл ажлыг бусдаар албадан хийлгэх. Албадан зарах (хүчээр зарах), хөлслөн зарах (тодорхой хөлс төлөн ажил үйл хийлгэх)

2/ Аар саар ажилд туслалцах, гар хөлийн үзүүрт зарах (гэр ахуйн ойр зуур ажилд зарах)

3/ Илгээх, явуулах: бичиг зарах (бичиг илгээх), хүн зарах (хүн явуулах), элч зарах (элч довтолгох)

4/ Юмыг эдлэж хэрэглэх: засвард зарах юмс (засварын ажилд зориулах юмс), захар зоос (хэрэглэх зоос), өртөө улаанд зарах морь (өртөө улаанд хэрэглэх морь), хоол хүнсэнд зарах (хоол хүнсэнд хэрэглэх)

5/ Худалдах, борлуулах, зарах идэх (худалдан борлуулж, олз ашгаар нь хүнс залгах), унаа зарах (унаа худалдаалах), махалж зарах (малын махыг жижиглэн зарах, аливаа бүтэн зүйлийг салган эд ангиар нь хэсэглэн зарах, зарах худалдах (ямар нэгэн зүйлийг бусдад худалдан борлуулж, мөнгө төлбөр олох), зарсан хойноо занах (тусыг муу санаагаар хариулах)

3. “Одоох монгол хэлний тайлбар толь” дахь “зарах”-ын утгын тайлбар:

1/ Өөрийн ажлаа бусдаар хийлгэх: зарц ~

2/ Ямар нэгэн явдалд захидал чимээ буюу тусгай хүнийг өөр газар илгээх, явуулах: бичиг ~

3/ Юмыг эдлэх зарцуулах: зоос ~

4/ Худалдан борлуулах: худалдаж ~

5/ Мах бэлтгэхийн төлөө малаа алах: хонь ~

Эдгээр бол орчин одоо үеийн монгол хэлний өвөр халх аялгуу дахь төлөөлөх чанартай толь бичгүүд дэх “зарах” гэдэг үгийн тухай тайлбар болно. Эдгээр тайлбаруудыг хураангуйлбал одоо үеийн монгол хэлний “зарах” гэдэг үг нь “бусдаар ажил хийлгэх, элч явуулах, эдлэж хэрэглэх, худалдах борлуулах, нядлах, ажилд туслуулах” гэсэн утгатай байж дундад эртний монгол хэлэн дэх утгатай харьцуулхад “худалдан борлуулах, нядлах” гэдэг цоо шинэ утга нэмэгдэж харин “оюун ухаанаа зарцуулах, тархиа хөдөлгөх” гэдэг утга нь гээгдсэн байна.

Энэ тухай нарийн тайлбарлавал:

1/ Халх аялгууг судлагчдын гаргасан толь бичигт “зарах” гэдэг үг нь “бусдаар ажил хийлгэх, элч явуулах, эдэлж хэрэглэх, худалдан борлуулах, ажилд туслуулах”⁸ зэрэг утгатай. Гэвч өдөр тутмын яриа эсхүл сонин нийтлэлд “зарах”-ын “худалдан борлуулах, мөнгө төгрөг сольж амьдралаа аргацаах” утга нь илт өргөнөөр хэрэглэгдэж, салбар утга жич үндсэн утга нь балархайшсан байна. Энэ тухай миний ажиглалтаар:

⁸ Ш.Чоймаа, М.Баярсайхан, С.Батхишиг нарын найруулсан (2012), Монгол хэлний хадмал толь (кирил монгол тайлбар, Соёмбо принтинг хэвлэлийн үйлдвэр).

1. Халхын яриа дахь “зарах”-ын үндсэн утга “ажилд зарах (бусдаар ажил хийлгэх)-ыг “ажил хийлгэх”, “ажилд оруулах” гэж илтгэж байна.

2. “Зарах”-ын “элч явуулах, эдэлж, хэрэглэх, ажилд туслуулах” утга нь нэгэнт балархайшиж хүмүүст ойлгогдохоо больсон байна.

3. Халх ярианд “зарах” гэдэг үг нь нэгмөсөн “худалдах борлуулах” утгатай болж “ашиг хонжвор олох, амьдрал аргацаах” талаар илүү хэлбийж буй. Жишээлбэл, Зайсанд 5 өрх бүх цонх нь наран талдаа 3-00-той орон сууц яаралтай зарна. (Зар мэдээ сониноос)

4. Онцгой нэг зүйл гэвэл, “махалж зарах” гэсэн хоршоо үгэнд “малын махыг жижиглэн зарах, аливаа бүтэн зүйлийг салган эд ангиар нь хэсэглэн зарах” гэсэн утгатай байна. Үүнийг өвөр монголын аялгуунд “үелж худалдах (мөчилж худалдах)” гэхээр илтгэнэ.

5. Өвөр монголын яриан дахь “зарах” гэдэг үгийн утгын хэрэглээ нь бас маш сонирхолтой байна. Толь бичиг дэх тайлбар нь “бусдаар ажил хийлгэх, элч явуулах, эдэлж хэрэглэх, худалдан борлуулах, нядлах, ажилд туслуулах” гэж буй. Гэвч энгийн хэлний хэрэглээнд “бусдаар ажил хийлгэх, эдэлж хэрэглэх, ажилд туслуулах” нь байнга орж “элч явуулах, худалдан борлуулах” утга нь балархайших хандаштай байна. Тухайлбал:

1. Өвөр монгол “зарах”-ыг үндсэн утгаар нь хэрэглэж “ажилд зарах, явдалд зарах” гэж байнга хэрэглэнэ.

2. Халхтай адил “элч явуулах” гэсэн утга нь бүр балархайшжээ. Харин “эдэлж хэрэглэх”, “ажилд туслуулах” мөн хэрэглээнд байна. Жишээлбэл: зоос зарах, хадланд зарах гэх мэт.

3. “Худалдаж борлуулах” гэсэн утга нь халх ба өвөр монгол их ялгаатай байж, нэг нь өргөнөөр хэрэглэн үндсэн утгыг нь орлох байдалтай байхад нөгөөд нь балархайших байдал оршиж буй. Гэвч “хонь зарах (мал зарах)” гэсэн холбоо үгэнд нутгийн аялгууны зөрөө оршдог. Даруй баруун монголын “хонь зарах (мал зарах)” гэдэг нь “хонь малыг алж нядлан хүнс бэлтгэх” гэсэн утгатай байхад, хорчин зэрэг орон нутагт “худалдаж борлуулах” гэсэн утгатай болж байна. Нэн Өвөр Монголын Шилийн гол аймгын Сүнэд хошуу тийшээ “хонь зарах” ба “хонион зарах” гэж хамаатуулахын “-оон”-оор “алж нядлан” ба “худалдаж борлуулах” гэх утгыг ялгаж буй.

Ерөнхийлвөл, монгол хэлний “зарах” гэдэг үг нь монгол хэлний үгийн сангийн хуучин үг мөртөө олон утгат үг байж, утгын хувьслагдсан нь монгол хэлний хөгжлийн ул мөрийг мэр сэр ойлгож болно. Нэн орчин одоо үеийн монгол хэлний үгийн сан дахь “зарах” гэдэг үг нь түүх, улс төр, газар зүй, үг хэл, үсэг бичиг, соёлын харилцаа, аж ахуй зэргээс шалтгаалж хэл аялгууны хувьд илтэд утгын зөрөө гарч байна. Бодтойгоор яривал, өвөр монгол ба халх аялгуун дахь “зарах” гэдэг үгийн утгын хувьсал нь хоёр өөр хандаштай болж буй. Даруй өвөр монгол дахь “зарах” нь олон утгат үг хэвээр байхад халхад энэ нь дан утгат үг болох гэж байна. Харин олон утгад нь дан утгаа агуулах ёстой байхад, өвөр монголын “зарах”-д халхын “худалдаж борлуулах” гэдэг утга балархайшиж буй. Энэ мэт “зарах” гэдэг үгтэй адилхан үгийн утгын ондоо хөгжилтэй үгс халх, өвөр аялгуунд мунгүй олон тохиолдож байна. Иймэрхүү үгийн утгын ондоошил нь хоёр аялгууны үгийн сангийн утга ондоошил үүсгэж нэг хэлний хоёр үгийн сан, хоёр үсэг бичгийн улмаас хоёр хэл болгох аюултай.

НОМЗҮЙ

Дов (1983), “Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд”, Үндэстний хэвлэлийн хороо.

“Монгол хэлний баримжаа авианы толь” (1983), Өвөр монголын ардын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Рашдонров (1989), “Сурагчийн монгол хэлний толь”, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Сэцэнцогт (1988), “Монгол үгсийн язгуур толь”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Зоригт, Оюунтана (2010), “Одоох монгол хэлний тайлбар толь (*хос үгийн хэвлэл*), Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Гарьд (2007), “Орчин цагийн монгол хэл”, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Баяр (1980), “Монголын нууц товчоо”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Ш.Чоймаа, М.Баярсайхан, С.Батхишиг (2012), “Монгол хэлний хадмал толь (кирил монгол тайлбар), Соёмбо принтинг хэвлэлийн үйлдвэр.

Л.Чулуунпүрэв (2011), “Монгол хэлний хэвшмэл хэлцийн толь”, Монсдар хэвлэлийн газар.

SUMMURY

This article deals with the meaning and usage of a Mongolian verb ‘*zarah*’ . The basic meaning of the word ‘*zarah*’ has been analyzed from written monuments and the derived meanings of the verb have been examined in contemporary Mongolian. Defining the differences of usage of the verb ‘*zarah*’ in Inner Khalkha dialects, this paper is an attempt to explain it by the feature of a derived meaning of a single verb in Mongolian lexicology.